**УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ**
**ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 10 сарын 05 өдөр Дугаар А/49 Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/322 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 18 нэрийн төрлийн 26 ширхэг 21,373,225 (хорин нэгэн сая гурван зуун далан гурван мянга хоёр зуун хорин тав) төгрөгийн үнэ бүхий машин тоног төхөөрөмж, 19 нэр төрлийн 26 ширхэг 5,604,230 (таван сая зургаан зуун дөрвөн мянга хоёр зуун гуч) төгрөгийн тавилга эд хогшил, 8 нэр төрлийн 15 ширхэг 2,942,000 (хоёр сая есөн зуун дөчин хоёр мянга) төгрөгийн түүх, соёлын дурсгалт зүйлсэд бүртгэлтэй үзмэрийн туслах хэрэглэгдэхүүнийг акталж, данс бүртгэлээс хассугай.

2.Данснаас хасагдаж буй үндсэн хөрөнгөөс 28 нэр төрлийн 10,474,580 (арван сая дөрвөн зуун далан дөрвөн мянга таван зуун ная ) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 27 нэр төрлийн 19,444,875 (арван есөн сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга найман зуун далан тав ) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 440,000 (дөрвөн зуун дөчин мянга ) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь 132,000 (нэг зуун гучин мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дансанд шилжүүлэхийг Өмч хамгаалах байнгын зөвлөл (Б.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

3.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 29,919,455 (хорин есөн сая есөн зуун арван есөн мянга дөрвөн зуун тавин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг ахлах нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

4.Акталсан эд хөрөнгө устгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Б.Төгсжаргал | (Сан хөмрөгч) |
| Комиссын гишүүд: | С.Эрдэнэбат | ( Дизайнер) |
| | Ч.Өсөхжаргал | (Бүртгэл мэдээллийн санч) |
| | О.Алтантулхүүр | (Нярав) |

C:/2022/alban hereg/2022 A tush/docx

CamScanner

5.Актлагдсан эд хөрөнгийг зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгаж, дүнг өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулахыг эд хөрөнгө устгах комисс (Б.Тэгшжаргал)-д даалгасугай.

ЗАХИРАЛ П.ДАВААСҮРЭН

CamScanner